



МОНГОЛ УЛСЫН

ХУУЛЬ

2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр
Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирх~~өл~~ий хэрү үл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой үхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай ~~өв~~шөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж

2.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд заасна~~өөрөөр~~ заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдож олг~~ө~~шөөрлийг Газрын тухай¹, Газрын хэвлийн тухай², Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай³, Байгалийн ургамлын тухай⁴, Ан агнуурын тухай⁵, Амьтны аймгийн тухай⁶, Ойн тухай⁷, Усны тухай⁸, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн

¹ Газрын тухай –"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 2 дугаарт нийтлэгдсэн.

² Газрын хэвлийн тухай –"Хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл" сэтгүүлийн 1988 оны № 11 дугаарт нийтлэгдсэн.

³ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай –"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 2 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Байгалийн ургамлын тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Ан агнуурын тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Амьтны аймгийн тухай –"ТМ" сэтгүүлийн 2000 оны № 19 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Ойн тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Усны тухай-"ТМ" сэтгүүлийн 1995 оны № 5-6 дугаарт нийтлэгдсэн.

гадаад худалдааг зохицуулах тухай, Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай, Хувиргасан амьд организмын тухай хуулиар тус тус зохицуулна.
/Энэ хэсэгт 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар, 2007 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт оруулсан/
/Энэ хэсэгт 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.” аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ –гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг;

3.1.2. “тусгай зөвшөөрөл эзэмшигч “ гэж тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

4 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн агуулга

4.1. Тусгай зөвшөөрөлд дор дурдсан зүйлийг тусгана:

- 4.1.1. тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;
- 4.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг;
- 4.1.3. эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл;
- 4.1.4. тусгай зөвшөөрлийн хугацаа;
- 4.1.5. тусгай зөвшөөрлөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;
- 4.1.6. тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон он, сар, өдөр;
- 4.1.7. тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүх ий албан тушаалтны гарын үсэг, тамга /тэмдэг/.

5 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээ

5.1. Тусгай зөвшөөрөл шаардах аж ахуйн үйл ажиллагааг хэрэв тусгайлан заасан бол тухайн нутаг дэвсгэрт явуулна.

5.2. Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн бүртгэх байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.

5.3. Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

5.4. Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ.

[/Энэ хэсгийг 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

6 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

6.1. Хуульдөөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

6.2. Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.

6.3. Хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана.

6.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох журам

7.1. Энэ хуулийн 15 дугаар үйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно.

7.2. Үх төрлийн хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоолны үйлчилгээг үйлдвэрлэлийн нөхцөл, технологийн ажиллагаа, бүтээгдэхүүнийхээ дээжийг зохих хяналтын байгууллагад шалгуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.

7.3. Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.

7.4. Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож болно.

8 дугаар зүйл. Хориглох аж ахуйн үйл ажиллагаа

8.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

8.1.1. хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах;

[/Энэ заалтад 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар “хар тамхи” гэсний дараа “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэлт оруулсан/](#)

8.1.2. садар самуун явдлыг зохион байгуулах, таливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих;

8.1.3. казиногийн үйл ажиллагаа эрхлэх;
8.1.4. олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа.

8.2. Энэ хуулийн 8.1.3 дахь заалт нь чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжид хамаарахгүй

[/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах зарчим , шаардлага

9.1. Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохдоо дараахь зарчмыг баримтална:

9.1.1. улс орныг батлан хамгаалах болон аюулбайдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

9.1.2. аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх;

9.1.3. ил тод, шуурхай байх ;

9.1.4. зөвхөн хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох .

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох байгууллагын эрх

10.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь дараахь эрхтэй :

10.1.1. хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох;

10.1.2. тусгай зөвшөөрлийг бүртгэх;

10.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;

10.1.4. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх;

10.1.5. тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

11.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ :

11.1.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/;

11.1.2. тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

11.1.3. тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

11.1.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

11.1.5. тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;

11.1.6. энэ хуулийн 15.5.7; 15.5.8; 15.6.1-15.6.3; 15.6.5; 15.8.3; 15.8.8; 15.8.18; 15.8.20; 15.10.4.-15.10.6; 15.10.14; 15.11.1; 15.11.2; 15.12.1-15.12.6-д заасан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг авсан байна.

[/Энэ заалтад 2005 оны 7 дугаар 1-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

11.2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардаж болохгүй.

11.3. Энэ хуулийн 15.10.5, 15.10.6-д заасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход аймаг, нийслэлийн Засаг дарга саналаа 30 хоногийн дотор Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлээгүй бол зөвшөөрсөн гэж үзнэ.

[/Энэ хэсгийг 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

12.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

12.2. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.

12.3. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

12.4. Магадлан шинжилгээ хийлгэх тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно.

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

13.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын үндэслэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

13.2. Тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

13.3. Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уул зөвшөөрлийг сэргээнэ.

14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

14.1. Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь дараахь тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

14.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

14.1.2. хуулийн этгээд татан буугдсан;

14.1.3. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон ;

14.1.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

[/Энэ заалтад 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

14.1.5. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

14.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл

15.1. Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.

15.2. Банкны үйл ажиллагааны чиглэлээр:

15.2.1. банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх.

~~15.2.2. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх~~

[/Энэ заалтыг 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

15.3. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

15.3.1. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.2. арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

15.3.3. даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.4. банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн ажиллагаа эрхлэх;

15.3.5. андеррайтер, брокер, дилер, нэт цаасны арилжаа эрхлэх, түүнчлэн үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах.

[/Дээрх 15.3. дахь хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

15.4. Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

15.4.1. нийгмийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

[/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

15.4.2. аудитын үйл ажиллагаа эрхлэх;

15.4.3. үнэт цаас үйлдвэрлэх;

15.4.4. эд мөнгөний хонжворт сугалаа гаргах.

~~15.4.5. татваргүй барааны дэлгүүр ажиллуулах;~~

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

~~15.4.6. гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үйлчилгээ эрхлэх;~~

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.4.7. гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.4.8. гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх;

/Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

15.4.9. хөрөнгийн үнэлгээ хийх.

/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

15.5. Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр:

~~15.5.1. хөрөнгийн үнэлгээ хийх;~~

/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.5.2. шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулгын ажил эрхлэх;

15.5.3. өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх;

15.5.4. нотариатын үйл ажиллагаа эрхлэх;

15.5.5. Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл /Төрийн мэдээллээс бусад/ хэвлэх;

~~15.5.6. тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх;~~

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.5.7. төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах;

15.5.8. галт зэвсэг үйлдвэрлэх, худалдах;

~~15.5.9. зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах;~~

/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

~~15.5.10. патентын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах;~~

/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.5.11. тамга, тэмдэг үйлдвэрлэх.

/Энэ заалтыг 2004 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/

15.6. Байгаль орчны чиглэлээр:

15.6.1. озон задалдаг бодифүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах;

15.6.2. тэсэрч, дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчилсөн/](#)

15.6.3. химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах;

[/Энэ заалтыг 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчилсөн/](#)

[/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

~~15.6.4. газрын кадастрын судалгаа хийх;~~

[/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

15.6.5. стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах;

15.6.6. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх;

15.6.7. байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх.

[/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.7. Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:

15.7.1. их сургууль, дээд сургууль, коллеж байгуулах;

[/Энэ заалтыг 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

15.7.2. магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх;

15.7.3. түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх;

15.7.4. дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах.

15.7.5. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах;

[/Энэ заалтыг 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.7.6. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинэ мэргэжлээр сургалт явуулах.

[/Энэ заалтыг 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.8. Түлш, эрчим хүчний чиглэлээр:

~~15.8.1. цөмийн эрчим хүчний нөөцөөр ажиллах эх үүсвэр барьж байгуулах, ажиллуулах;~~

[/Энэ заалтыг 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

15.8.2. эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах;

15.8.3. эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх;

~~15.8.4. шингэрүүлсэн шатдаг хийн үйлчилгээ эрхлэх.~~

/Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.8.5. зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх.

/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

*/Дээрх 15.8 дахь хэсэгт 2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/
Энэ хэсгийг 2005 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

15.9. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

15.9.1. гадаадад ажиллах үч гаргах, гадаадаас ажиллах хүч авах, хөдөлмөр эрхлүүлэх талаар иргэдэд зуучлах үйлчилгээ эрхлэх.

15.10. Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр:

15.10.1. одон, медаль, үйлдвэрлэх;

/Энэ заалтад 2004 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

15.10.2. үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх;

~~15.10.3. мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх хорт бодис худалдах;~~

/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

~~15.10.4. химийн хорт болон аюултай бодис экспортлох, худалдах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах;~~

/Энэ заалтад 2004 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан ба 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

15.10.5. ашигт малтмалын хайгуул хийх;

15.10.6. ашигт малтмал ашиглах;

~~15.10.7. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;~~

/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

~~15.10.8. хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах;~~

/Энэ заалтад 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан ба 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

~~15.10.9. хэмжих хэрэгслийн шалгалт, төхирүүлэл ажил, үйлчилгээ эрхлэх;~~

/Энэ заалтыг 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон /

~~15.10.10. чанарын баталгаажуулалтын үйлчилгээ эрхлэх;~~

/Энэ заалтыг 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон /

15.10.11. газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах.

15.10.12. согтууруулах ундаа импортлох.

[/Энэ заалтыг 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.10.13. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх;

[/Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.10.14. тамхи импортлох;

[/Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.10.15. төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх.

[/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.11. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

15.11.1. тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх;

15.11.2. сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх;

15.11.3. таримал ургамлын үр үйлдвэрлэх;

15.11.4. малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох;

15.11.5. малын өвчин үүсгэгчийг ургуулж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх;

15.11.6. ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах;

15.11.7. шинээр зохион бүтээсэн болон гадаадаас авсан мал, амьтны эм, үр, үр хөврөлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах, үржлийн мал, амьтныг гадаадад гаргах;

15.11.8. мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл, үйлдвэрлэх;

15.11.9. ургамал хамгааллын үйл ажиллагаа эрхлэх.

[/Энэ заалтыг 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.12. Эрүүл мэндийн чиглэлээр:

15.12.1. мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэх;

15.12.2. хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох;

[/Дээрх “багаж, тоног төхөөрөмж, протез”, “импортлох” гэснийг 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.12.3. эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх;

15.12.4. мансууруулах болон сэтгэцэд өлөөлөх эм, бодис, тэдгээрийн угтвар бодис болон эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, импортлох;

[/Энэ зээлтэд 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар “үйлдвэрлэл, худалдаа эрхлэх” гэсний дараа “импортлох” гэж нэмэлт оруулсан/](#)

15.12.5. улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

15.12.6. өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх;

15.12.7. [/Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

15.12.8. ахуйн шавьж, мэрэгч устгах, халдажүүлэх үйлчилгээ эрхлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.12.9. биологийн идэвхтүйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх;

[/Энэ заалтыг 2006 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.12.10. гадаадын жоронго оруулалттай хуулийн этгээд эмчилгээний гоо заслын үйлчилгээ эрхлэх.

[/Энэ заалтыг 2006 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.13. Зохиогчийн эрх, патентын чиглэлээр:

15.13.1. зохиогчийн эрхэд хамаарах элбэн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах;

15.13.2. патентын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах.

[/Дээрх 15.13 дахь хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.14. Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

15.14.1. нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг хэвлэх;

15.14.2. кадастрын зураглал хийх;

15.14.3. цахилгаан шат, өргөх краны угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;

~~15.14.4. зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт засвар, үйлчилгээ эрхлэх;~~

[/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

15.14.5. нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

15.14.6. барилга байгууламжийн зурагдөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх;

[/Энэ заалтад 2008 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

15.14.7. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

15.14.8. газрын кадастрын судалгаа хийх.

[/Дээрх 15.14 дэх хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.15. Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр:

15.15.1. төмөр замын суурь бүтэц барих, ашиглах;

[/Энэ заалтыг 2007 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

15.15.2.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

15.15.3. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;

[/Энэ заалтыг 2007 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

15.15.4. автозам, замын байгууламжийг барих, засварлах ;

15.15.5. автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх;

15.15.6.улс хоорондын болон хот хоорондын нийтийн тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлт, улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх;

[/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

15.15.7. иргэний агаарын жлгийг бүтээх, түүнд өөрчлөлт сайжруулалт хийх;

15.15.8. дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх;

15.15.9. усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх;

15.15.10.усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар эрхлэх;

15.15.11. төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;

[/Энэ заалтыг 2007 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.15.12.тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх.

[/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Дээрх 15.15 дахь хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.16. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:

15.16.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;

15.16.2.харилцаа холбооныүйлчилгээний сүлжээ ба йгуулах, үүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх.

[/Дээрх 15.16 дахь хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.17.Стандарчлал, хэмжил зүйн чиглэлээр:

15.17.1.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах.

[/Дээрх 15.17 дахь хэсгийг 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

15.18.Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр:

15.18.1.цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;

15.18.2.цөмийн төхөөрөмж ашиглах;
15.18.3.цөмийн бодис эзэмших, ашиглах;
15.18.4.цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг
булшлах;

15.18.5.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;
15.18.6.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;
15.18.7.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох,
тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх;

15.18.8.цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах,
байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах,
тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон
түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

[/Дээрх 15.18 дахь хэсгийг 2009 оны 07 дугаар сарын 16-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

**16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга,
мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл
олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл**

[/Энэ зүйлийн гарчигт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

~~16.1. Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд мэргэжлийн хяналтын
байгууллага тусгай зөвшөөрөл олгоно:~~

~~*[/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт оруулсан/](#)*~~

~~16.1.1. цацраг идэвхт ашигт малтмал, бусад цацрагийн үүсгэвэртэй
холбоотой үйл ажиллагаа эрхлэх;~~

~~*[/Энэ хэсгийг 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)*~~

16.2. Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд Аймаг, нийслэлийн Засаг
дарга тусгай зөвшөөрөл олгоно:

16.2.1. аймаг хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын
нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх ;

16.2.2. эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

~~16.2.3.хорттой, бага хорттой химийн бодис үйлдвэрлэх, импортлох,
устгаж;~~

~~*[/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)*~~

16.2.4. ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах;

[/Энэ 16.2.4 дэх заалтад 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

16.2.5. согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.

16.2.6.эмчилгээний гоо заслын үйлчилгээ.

[/Дээрхи 16.2.6 дахь заалтыг 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

16.3. Дараахь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд сум, дүүргийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно:

16.3.1. агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой влөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах;

16.3.2. орон нутагт нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх /энэ заалт дүүргийн Засаг даргад хамаарахгүй/;

~~16.3.3. цэцэрлэг байгуулах;~~

[/Энэ 16.3.3 дахь заалтыг 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

16.3.4. тамхи худалдах.

[/Энэ заалтыг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон маргааныг шийдвэрлэх

17.1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох дээд шатны байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1. Энэ хуулийг өрсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

18.1.1. энэ хуулийн 15, 16 дугаар зүйлд заасан аж ахуйн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 20000 - 50000, хуулийн этгээдийг 100000 – 250000 төгрөгөөр торгох ;

18.1.2. энэ хуулийн 7.2-ыг өрсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 20000–50000, хуулийн этгээдийг 100000–250000 төгрөгөөр торгох;

18.1.3. энэ хуулийн 5.3-ыг өрсөн иргэнийг 20000 -50000, албан тушаалтныг 30000-60000, хуулийн этгээдийг 100000-250000 төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

18.1.4. хуурамч бичиг баримт үлдүүлж тусгай зөвшөөрөл авсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 20000 – 50000, хуулийн этгээдийг 100000-250000 төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

18.1.5. энэ хуулийн 6.3, 11.2, 12.1, 12.4, 13.2, 14.2-ыг зэрчсэн албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгох.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

19.1. Энэ хуулийг 2002 оны үлд сарын 1 –ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

[/Энэ хэсгийг 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ